

2026.06.15 Нэгж талбар нэгтгэн газар
эзэмшүүлэх тухай А/391

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Б.Тэмүүжин /ГЗ99073019/-ийн гаргасан хүсэлтийн дагуу Уртын гол баг, Баянтал-9-50а тоот хаягт байрлах гэр, орон сууцны хашааны газрын зориулалттай /6105143766/ 625 м.кв, /6105143891/ 306 м.кв газрын нэгж талбаруудыг нэгтгэн нийт 931 м.кв газрыг гэр, орон сууцны хашааны газрын зориулалтаар 5 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Энэ захирамж гарсантай холбогдуулан иргэн Б.Тэмүүжинд газар эзэмших эрх олгосон сумын Засаг даргын 2025 оны А/250 дугаар захирамжийн хавсралтын 1 дүгээр мөр, 2026 оны А/114 дүгээр захирамжийн хавсралтын 18 дугаар мөрийг тус тус хүчингүй болгосугай.

3. Газрын хэмжээ өөрчлүүлсэн иргэнтэй шинээр газар эзэмших гэрээ байгуулан гэрчилгээ олгож, улсын бүртгэлд бүртгэх ажлыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг Газрын даамал (Г.Отгонбаяр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.МӨНХБАЯР